

**Монголын Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын  
Ажлын хэсгийн хуралдааны тэмдэглэл /2017-11-15/**

Ажлын хэсгийн 45 дугаар хуралдаан 2017 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн 10.00 цагт Пума ИмпериаЛ зочид буудлын 2 давхарын хурлын танхимд зохиогдов.

Ажлын хэсгийн хуралдаанд Ерөнхий сайдын ахлах зөвлөх, Ажлын хэсгийн ахлагч Б.Энх-Амгалан, Ашигт малтмал, газрын тосны газрын дарга Б.Баатарцогт, мэргэжилтэн Г.Оюунтуяа, Засгийн газрын хэрэг эрхлэх газрын ахлах референт Э.Сумъяа, Сангийн яамны нягтлан бодох бүртгэлийн газрын мэргэжилтэн Г.Зулай, БОАЖЯ-ны ахлах мэргэжилтэн Б.Саран, Татварын ерөнхий газрын ОУИТБС-ыг хариуцсан татварын байцаагч Ж.Батцэнгэл, Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын Байгаль орчин, геологи уул уурхайн хяналтын газрын дарга Н.Батбаяр, Авлигатай тэмцэх газрын Соён гэгээрүүлэх, урьдчилан сэргийлэх хэлтсийн дарга Т.Баярхүү, Төлсөн авснаа нийтэл эвслийн тэргүүн Д.Эрдэнэчимэг, Байгаль эхийн аврал сан ТББ-ийн тэргүүн Б.Наранцэцэг, Ил тод сан ТББ-ийн гүйцэтгэх захирал Д.Цэрэнжав, Хөвсгөл далайн эзэд ТББ-ийн тэргүүн Б.Баярмаа, Хүний эрх хөгжил төвийн ажилтан н.Баасанхүү, Миний монголын газар шороо хөдөлгөөний гүйцэтгэх н.Отгонсайхан, Транспаренси интернэйшнл монгол байгууллагын ерөнхийлөгч Л.Төр-од, Монголын уул уурхайн үндэсний ассоциацийн гүйцэтгэх захирал Д.Энхболд, Алт үйлдвэрлэгчдийн холбооны ажлын албаны дарга Н.Наранзаяа, Бороо гоулд ХХК-ын Орон нутгийн төсөв захиргаа хариуцсан ажилтан Ж.Энхтуул, Оюутолгой ХХК-ийн ахлах менежер Г.Мөнхбат, Петроматад ХХК-ны гүйцэтгэх захирал Т.Амарзул, Петрочайна дачин тамсаг ХХК-ны нягтлан бодогч н.Болормаа, Ажлын хэсгийн нарийн бичгийн дарга, ажлын албаны зохицуулагч Ш.Цолмон нар оролцов. Хуралд ажлын хэсгийн 33 гишүүнээс 23 гишүүн оролцож, ирц 66,7 хувьтай байв.

Мөн хуралдаанд Кэй Пи Эм Жи Франц түншлэлийн партнер Марк Эберт, зөвлөх үйлчилгээний менежер Ш.Номиндарь, захирал Соёлмаа, ЗГХЭГ-ийн референт Гандөл, шинжээч Цэрэнжүрмэд, Интерконсалтинг ХХК-ны гүйцэтгэх захирал Н.Энхжаргал, Эрдэнэс Монгол ХХК-ны ажилтан Мэндбаяр, болон ажлын албаны харилцааны мэргэжилтэн Б.Дэлгэрмаа, санхүүгийн ажилтан А.Отгонтунгалаг, Мэдээлэлийн технологийн зөвлөх Г.Ганбат нар оролцов.

Хуралдааныг Ерөнхий сайдын ахлах зөвлөх Б.Энх-Амгалан нээж, хурлын хэлэлцэх асуудал болон дотоод журмыг танилцуулснаар хурал эхлэв.

Б.Энх-Амгалан: Сайн байцгаана уу, Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе. Оролцогч нартай танилцсандаа баяртай байна. Шинэ Засгийн газар байгуулагдсан, Засгийн газрыг МУ-ын Ерөнхий сайд Хүрэлсүх удирдан ажиллаж байна. Ерөнхий сайдын эрхлэх асуудлын хүрээнд 20 гаруй төсөл хөтөлбөр, нэгж, зөвлөлүүд байдаг, үүнээс идэвхтэй үйл ажиллагаа явуулж байгаа нь ОУИТБС байна. Ажлын албаны уламжлалт хурал болж байна, зөвлөлийн хуралд амжилт хүсье. Засгийн газраас уул уурхайн баялгийн шударга хуваарилалтыг баримтлах бодлого барьж ажиллана. Энэ нь Ерөнхий сайдын хувийн үзэл бодол төдийгүй, Засгийн газрын баримталж байгаа бодлого юм. Уул уурхай нэг хэсэгтээ манай эдийн засгийн суурь хөдөлгөгч хүч байх болно. Уул уурхай хөгжих ёстой, хөгжих явцдаа хүрээлэн байгаа орчиндоо аюулгүй, олсон орлого нь хөгжилд чиглэсэн, эргээд нийгмийн сайн сайхны төлөө зориулагддаг, шударга хуваарилалттай уул уурхайг сонирхож байна. Ийм үйл ажиллагааг явуулахад гаднын санхүүжилтээр

хэрэгжиж байгаа, ОУИТБС-ын үйл ажиллагаа үнэхээр чухал юм. Бидний үүрэг нэмэгдэж, зорилтууд улам тодорхой болж байна. Өнөөдрийн Засгийн газрын хуралдаанаар олон улсын гишүүнчлэлийн татварын асуудал шийдэгдэж байна. Цаашдаа бидний ажиллагаа хумигдах, хязгаарлагдах биш, улам илүү ил тод болно гэдэгт итгэлтэй байна. Хурлын үйл ажиллагаа нээгдсэнийг мэдэгдье. Хурлын үйл ажиллагаагаар хязгаарлахгүй санал байвал холбогдож болно. Та бүхний хамтын ажиллагаанд амжилт хүсье. Ерөнхий сайдын ажлын албаны референт Гандөл, шинжээч Цэрэнжүрмэд нарыг дахин танилцуулъя. Төслийн үйл ажиллагаанд оролцон ажиллах үүрэгтэй ажиллах хүмүүс юм. Өнөөдрийн хуралдааны хөтөлбөрийн дагуу нэгдүгээр асуудлыг Кэй Пи Эм Жи аудитын зөвлөх Номиндарь танилцуулна.

### **I. ХЭЛЭЛЦСЭН нь: Монголын ОУИТБС-ын 2016 оны нэгтгэлийн тайлангийн төслийн танилцуулга**

Марк Эберт: Сайн байцгаана уу, юуны өмнө бидэнд итгэл хүлээлгэн хараат бус нэгтгэлийг хийхэд тусалж дэмжсэнд баярлалаа. Бид энэ жил хоёр дахь удаагаа хараат бус нэгтгэгчээр ажиллаж байна. Сүүлийн 3 сард тулган баталгаажуулалт болон бусад мэдээлэл, Монгол улсын баталгаажуулалттай холбоотой мэдээлэл дээр ажиллаж, үүний үр дүнд тайлангаа гаргасан. Монгол улс ирэх 1-р сард ОУИТБС-ын стандартын дагуу дахин баталгаажуулалтад орно. Энэ жил үүнд түлхүү анхаарч ажилласан, энэ талаар бүлэг танилцуулгыг оруулж өгсөн. Эцэст нь тайлангийн хүрээнд өгч байгаа зөвлөмжүүдийг дурдана. Зөвлөмжүүдийг цаашдаа хэрэгжүүлэх нь зүйтэй арга хэмжээнүүд гэж ойлгож болно. Одоо Номиндарь тайлангийн танилцуулгыг үргэлжлүүлэн хийнэ.

Ш.Номиндарь: Бид явцын тайлангийн төслийн хүрээнд гурван үндсэн зүйлийг танилцуулна. Үүнд, нэгдүгээрт тайлангийн явцад нэгтгэлд олж илрүүлсэн зүйл, олон улсын баталгаажуулалттай холбоотой асуудлыг тайландаа хэрхэн тусгасан талаар, гуравдугаарт тайлангийн хүрээнд гарсан зөвлөмжүүдийг дурдах болно.

Манайх нэгтгэлийг хийхдээ ажлын хэсэгтэй зөвшилцсөний дагуу материаллаг босгыг тогтоосон. Мөн ажлын хэсгийн хүсэлтээр улсын хэмжээнд болон орон нутгийн хэмжээнд гэсэн тус тусдаа босго тавьсан. Түүвэрт улсын хэмжээнд 50 саяас дээш, орон нутгийн хэмжээнд 30 саяас дээш төгрөгийн орлого оруулсан компанийг сонгож авсан. Засгийн газар 2016 онд нийтдээ 2079 компаниас орлого хүлээн авсан гэж бүртгэгдсэн. Эрсдэлд суурилсан аргачлал болон Засгийн газрын тайлагнасан гол орлогын дүнгүүдийг харгалзан үзсэнээр эдгээр компаниудаас материаллаг босго давсан, өндөр эрсдэлтэй 213 компанийг тулган баталгаажуулалтад сонгож авсан. Анхны тайлангаар Засгийн газар 1,16 их наяд төгрөгийн орлогыг компаниудаас хүлээн авсан гэж тайлагнасан. Засгийн газар компанийн хоорондох анхны зөрүү 105 тэрбум байсан, залруулга тулган баталгаажуулалт хийж, нэгтгэлийн дараа 74 сая болж буурсан.

Зарим компаниуд нэгтгэлийн мэдээллийн маягтыг ирүүлээгүй, нэгтгэлд шаардлагатай нэмэлт мэдээллийг өгөөгүйгээс 2 тэрбум төгрөгийн зөрүү үүсгэж байсан. Төрийн байгууллагаас Гаалийн ерөнхий газар болон Байгаль орчин аялал жуулчлалын яам мэдээлэл гаргаж өгөөгүй, нийлээд 12 тэрбум төгрөгийн зөрүү үүсгэж байсан. Нэгтгэлийн зөрүү дээр гарсан нийтлэг шалтгааныг дурдвал, компаниуд тайлангаа цахим тайланд тайлагнаагүй, төлбөрөө илүү тайлагнасан, төлбөрийн буруу төлбөрийн ангилал мэдээлсэн, буцаагдсан төлбөрийг компанийн

тайланд тохируулаагүй, өөр компанийн өмнөөс төлсөн төлбөрөө тайлагнасан, төлбөрүүд цэвэр дүнгээр бичигдсэн, өмнөх жилийн төлбөрийг энэ онд оруулсан, олборлох үйл ажиллагаанд хамааралгүй төлбөрүүд орсон гэх мэт. Гаалийн ерөнхий газар цахим тайланд мэдээллээ оруулсан боловч, нарийвчилсан мэдээллээ өгөөгүй учраас тулган баталгаажуулалтад оруулах боломжгүй байсан. БОАЖ яамнаас барьцаа төлбөр 50 хувийг байршуулсан талаарх мэдээллийг тодорхой шалтгааны улмаас өгөх боломжгүй гэсэн ч ямар нэгэн байдлаар бичгээр мэдэгдээгүй. Компаниудын зарим нь холбогдох ямар ч боломжгүй, зарим нь мэдээллээ өгөхөөс татгалзсан зэрэг 8 компани байсан. Нэмэлт мэдээлэл өгөхөөс татгалзсан болон холбогдоогүй 5 компани байсан. 2016 оны Засгийн газрын нийт орлого 5,8 их наяд төгрөг, үүнээс хамгийн их буюу 18,6 хувийг АМНАТ бүрдүүлсэн байна.

Монгол улс 2016 онд ОУИТБС-ын олон улсын стандартын баталгаажуулалтад орсон. Үүнээс ахиц гарсан улс гэсэн үнэлгээ авсан. Цаашдаа засаж залруулах хэд хэдэн арга хэмжээ байгаа гэсэн зөвлөмж гарсан. Энэ зөвлөмжийн хүрээнд тайланд тусгаж, залруулах боломжтой ажлыг хийж оруулсан. Бид тайлангийн төслийг ОУ-ын НБДНГазраас явуулсан. Баталгаажуулалтын хүрээнд тусгай зөвшөөрлийн олголт, бүртгэх мэдээлэлтэй холбоотой асуудлын талаар оруулах байсан. Залруулах шаардлагатай арга хэмжээ нь, 2016 онд тусгай зөвшөөрөл хэдийг олгосон, хэдийг шилжүүлсэн гэдгийг тайланд тусгах ёстой байсан. Хууль зүй дүрэм журмыг дагаж мөрдөөгүй тохиолдол ямар байсан талаар оруулах байсан. Мөн ОУИТБС-ын цахим тайлангийн лицензийн огноо болон солбилцлын цэгүүдийг бүрэн оруулах байсан. Бид 2016 оны лицензийн талаарх мэдээллийг бүрэн оруулж чадсан, хууль зүй дүрэм журмын талаар ямар арга барил хэрэглэсэн нь тодорхой бус байна гэсэн. ОУ-ын дарга нарын газраас эрсдэлтэй лицензийн жагсаалтыг аваад дахин шалгаж үзэх нь зүйтэй гэсэн тул бидний зүгээс ажлын хэсгээс хүсэхэд эрсдэлтэй гэж үзсэн лицензийг ярилцаад жагсаалтаа өгвөл тайландаа оруулах боломжтой. Мөн 2016 онд 37 компани лиценз авах сонгон шалгаруулалтад орсон байна. Эдгээр компаниудын мэдээллийг ил болгох ёстой. Одоогоор шалгарсан компаниудын мэдээлэл байгаа, шалгараагүй ялагдал хүлээсэн компанийн мэдээллийн жагсаалтыг ил болгох ёстой гэсэн. Энэ мэдээллийг Ашигт малтмалын газраас авах хүсэлт тавьсан ч ээн мэдээллийг ирүүлээгүй байна. Энэ мэдээллийг яаж олох вэ? та бүхэн туслалцаа үзүүлнэ үү. 2016 оны бүтээгдхүүн хуваах 2 гэрээ байгуулсан, үүнийг шууд зөвшилцөх замаар хийгдсэн талаарх мэдээллийг тайландаа оруулна. 2013 компанид байгаа 600 гаруй лицензийн өргөдлийн огноог ил болгоё гэсэн. АМГТГ-аас 200 гаруй лицензийн өргөдлийн огноог гаргаж өгсөн, бусад нь боломжгүй гэсэн гэхдээ яагаад болохгүй байгаа талаар албан ёсны хариуг ирүүлвэл тайландаа оруулах боломжтой. Бидний зүгээс 40 гаруй компаниас дээрх мэдээллээ гаргаж өгөхийг хүссэн, зарим боломжтой нь ирүүлсэн. Нийт нэгтгэлд орж байгаа 213 компанийн 110 компанийн мэдээллийг орж чадсан. ОУ-ын газраас бусад мэдээлэл яагаад олдох боломжгүй байгаа талаарх мэдээллээ оруулахыг хүссэн байгаа. Дараагийн асуудал бол төрийн өмчийн аж ахуйн нэгжүүдийн талаарх мэдээлэл байна. Шаардлага 2.6а, 4.5 болон 6.2 буюу ТӨААН-тэй холбоотой гүйлгээ, төсвийн шинжтэй зарцуулалтын талаар ТӨААН-ын хуримтлагдсан ашиг, дахин хөрөнгө оруулалтын талаарх дүрэм журам, практик дээр ямар байдаг талаар ТӨААН-тэй уулзаж тодруулга авч, тайланд оруулсан. Мэдээллийг баталгаажуулах ямар нэгэн арга барил бий болгох хэрэгтэй гэсэн. Бид эхлэлтийн семинарын үеэр ажлын хэсгээр ярилцаад, 2016 оны хувьд муу баталгаажуулалтай компанийн тоог 16% хүртэл бууруулах болсон. Орлогын урсгалаар авч үзвэл муу баталгаажуулалттай компани 1%-ийг сайн баталгаажуулалттай компани орлогын 40%-ийг бүрдүүлсэн байна. ОУНБДНГ-аас дүгнэлтээ бичихийг зөвлөсөн, бид үүнийг оруулах боломжтой.

Түүнчлэн бусад залруулга, тайлбар тодруулгыг оруулсан. 2016 оны нэгтгэл тайлангийн хүрээнд дараах зөвлөмжүүдийг өгч байна. Үүнд, төрийн байгууллагуудаас тайлагнасан мэдээллийг баталгаажуулах журмыг амжилттай хэрэгжүүлэх ажлыг ҮАГ-тай хамтран зохион байгуулах, ОУИТБС-ын ач холбогдол болоод ОУИТБС-ын мэдээллийг бэлтгэдэг Засгийн газрын агентлагуудын хамтын ажиллагааны ач холбогдлыг таниулах ажлын төлөвлөгөөг Үндэсний зөвлөлөөр батлуулах, ТӨААН-үүдтэй холбоотой ОУИТБС-ын стандартын тухайлсан шаардлагуудын талаар сургалт зохион байгуулах, гарын авлага бэлтгэх гэх мэтээр ТӨААН-үүдийн чадавхийг бэхжүүлэх, цахим тайлангийн системд НӨАТ-ын дүнг хүлээн авагч тус бүрээр буюу Татварын алба болон Гаалийн албанд төлөгдсөн дүнгүүдийг хүлээн авагч байгууллагууд тус тусдаа тайлагнах боломжтойгоор, НӨАТ төлөгч компаниуд салгаж тайлагнах боломжтой байхаар шинэчлэх, ЗГ-ын түвшинд аливаа нэг аж ахуйн нэгж олборлох үйлдвэрлэлээс эсвэл өөр бусад бизнесийн үйл ажиллагаанаас олсон орлогын урсгалыг хооронд нь ялгаж, ангилах горимыг хэрхэн хэрэгжүүлэх талаар авч үзэх, ОУИТБС-ын стандартаар шаардсан наад захын шаардлагуудад нийцсэн мэдээллийг олон нийт авах боломжийг бүрдүүлэх үүднээс тусгай зөвшөөрлийн кадастрын мэдээллийг сайжруулах, Үндэсний зөвлөл энэ асуудлыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн яаманд тавьж, хүчин төгөлдөр байгаа Бүтээгдхүүн хуваах гэрээнүүдийг олон нийтэд ил тод болгох, орлогын урсгалыг төслийн түвшинд задлан харуулын тулд боломжтой нөхцөлд орлогын урсгалыг төслийн түвшинд хэрхэн ялгах талаар авч үзэх нь зүйтэй. /Танилцуулгыг хавсаргав/

Б.Энх-Амгалан: За баярлалаа, гишүүдээс 2016 оны тайлангийн танилцуулгатай холбоотой санал хэлэхийг хүсэж байна.

Б.Баатарцогт: За баярлалаа, манай байгууллагаас зарим мэдээллийг гаргагүй гэж байна. Мэдээллийн хувьд зөвхөн жагсаалт нь байх уу, бусад мэдээллүүд байх уу гэдгийг хязгаарлаж өгөх хэрэгтэй байх.

Ш.Номиндарь: ОУНБДнГазраас сонгон шалгаруулалтад орсон компанийн жагсаалт байхад болно гэсэн.

Б.Баатарцогт: Сонгон шалгаруулалтад орсон компанийн мэдээллийг гаргаж өгөх бүрэн боломжтой. Тусгай зөвшөөрлийн өргөдөл гаргасан огноо гэдгийн тухайд кадастрын архив гэж байгаа, зарим мэдээлэл хадгалагдаад байгаа, өмнөх олон жилийн өмнөх нь архивт хадгалагдаад явдаг, түүнд орсон мэдээлэл гарах боломжгүй. Ер нь манай кадастрын мэдээлэл харьцангуй ил тод болж байгаа. өргөдөл гаргасан огноо, шийдвэрлэсэн огноо зэрэг мэдээллийг 2016 оныхыг гаргах боломжтой, тэрнээс өмнөх нь архивт орсон бол хүндрэлтэй байдаг. Бүтээгдхүүн хуваах гэрээний кадастрын мэдээллийг ашигт малтмалын кадастарт нэгтгэж байгаа, энэ мэдээлэл ил тод болно, системээс харах боломжтой болно. Бүр 10-аад жилийн өмнө хийсэн солбилцол нь давхцах асуудал байгаа, үүнийг янзалж байгаа. Бүтээгдхүүн хуваах загвар гэрээг нээлттэй болгож болох талаар ярилцаж байгаа, өмнө нь байгуулагдсан бүтээгдхүүн хуваах гэрээнүүдийн шинэчлэх асуудал яригдаж байгаа. Манайд байгаа боломжтой мэдээллийг манайх гаргаж өгөх боломжтой.

Т.Амарзул: Танилцуулгад Сангийн яамнаас орон нутгийн шилжүүлэг улс, аймаг, сумруу дамнаж хийгддэг гэдгийг баталгаажуулсан гэж байна. Бидний хувьд

газрын тосны талбай том учраас аймаг сум дамнасан байдаг. Бид газрын төлбөрөө Сангийн яам юм уу, ашигт малтмалын газрын дансруу хийдэг, хөдөө орон нутгийнхан энэ төлбөр манай суманд орж ирэхгүй байна, энэ төлбөр нь төсөв дээр нэмэлт төсөв болж орж ирэх ёстой байтал төсөвт шингэж орж ирдэг талаар хэлдэг. Компанийн хувьд бид түүнийг тайлбарлаж өгч чаддаггүй. Хэрвээ үүнийг яг яаж хийгдэж байгааг тайлбарлаад өгвөл бид орон нутагт тайлбарлах боломжтой болох юм.

Г.Зулай: Энэ талаар төсвийн бодлогын газар зохицуулдаг, би өөр газар байдаг болохоор шууд хариулах боломжгүй байна. Би энэ талаар асууж тодруулаад дараагийн хурал дээр юмуу онлайнаар хариултыг явуулах боломжтой.

Ш.Номиндарь: Бид энэ талаар тайлбар хэлэхэд, манай тайлангийн хавсралт дээр байгаа. Ямар ямар аймаг руу хэдэн төгрөг шилжсэн гэдэг нь мөнгөн дүнгээрээ гарна, ил тод болсон. Энэ нь зөвхөн татвар биш өөр өөр дүнгүүд нийлж орж ирсэн байдаг. Сангийн яамны вэбсайтад, аймгаа дараад орохоор ямар төлбөр хэзээ хаашаа шилжсэнгийн харах боломжтой юм, линкийг тайландаа оруулсан байгаа. Тэр тайланг харвал нэмэлт мэдээллүүд гарах юм.

Н.Эрдэнэчимэг: Тайлангийн 25-р хуудсан дээр түүврийн аргаар компаниудыг сонгосон гэсэн, материаллаг босго нь 100 сая гэсэн байна. Энэ буруу дүн гэж ойлгох уу, засах ёстой юу?

Ш.Номиндарь: Тийм, материаллаг босго нь 50 сая гэдэг нь зөв.

Н.Эрдэнэчимэг: Танилцуулгад нэгтгэлд хамрагдсан компаниудын 63 нь аудитын тайлангаа ирүүлээгүй гэж байна. Эдгээр 76 компани аудит хийлгэсэн эсэх нь тодорхойгүй байна. Хэрвээ эдгээр компаниуд нь аудит хийлгээгүй бол НББ-ийн хуулиа зөрчиж байгаа юм биш үү? Хэрэв тийм бол үүнд хэн хариуцлага тооцох ёстой вэ? Иймд энэ талаар тайландаа зөвлөмж өгөх нь зүйтэй гэж ОУНБДнГ-аас хэлсэн.

Ш.Номиндарь: Аудитын тайлангаа ирүүлээгүй байсан 63 компаниас 47 нь төлөөллийн захидлаа явуулсан. Төлөөллийн захидалд ОУИТБС-ын тайлангаар өгсөн мэдээлэл нь үнэн зөв гэдгийг батласан учраас мэдээлэл илүү баталгаатай гэж үзээд тэдгээр компаниудыг муу дүнтэй баталгаажуулалтаас дунд муу дүнтэй баталгаажуулалт руу шилжүүлсэн. Тайлан ирүүлээгүй компаниас яг хэд нь тайлан гаргаагүй, хэд нь тайлангаа гаргасан боловч ирүүлээгүй гэдгийг нарийн гаргаж чадаагүй. Үлдсэн 20 гаруй компани нийт орлогын урсгалын 1 хувийг эзэлж байсан учраас бид үүнийг өндөр эрсдэлтэй гэж үзээгүй, жижигхэн компани тайлан гаргахгүй аудитлагдахгүй байх магадлалтай гэж үзсэн. ОУНБДнГ-аас энэ талаарх мэдээллийг оруулах хэрэгтэй гэсэн. Энэ дээр авч хэрэгжүүлж болох арга хэмжээ гэвэл Сангийн яамнаас аудитлагдах шаардлагатай компанийн жагсаалт гэж гарах байх. Үүнээс тухайн компани аудитлагдах эсэхийг тулгаж мэдэх боломжтой гэсэн мэдээллийг өгсөн.

Б.Баатарцогт: АМНАТ болон агаарын бохирдлын төлбөр орон нутагт орохгүй байна. Агаарын бохирдол орон нутагт нь байхад татвар нь хуваарилагдахгүй байна. Бид сая Өмнөговь аймагт зөвлөгөөнд оролцоод ирсэн, энэ талаар бас ярьж байсан. Иймээс энэ талаарх зөвлөмжийг тайландаа оруулж өгөх саналтай байна.

Б.Саран: Тайлан нэгтгэж байгаа хүнээс асуулт байна. Би ОУИТБС хэрэгжиж эхэлснээс хойш хамтран ажиллаж байгаа. ОУИТБС-ын тайланд олон зүйлийг хүсээд байдаггүй. Тухайн аж ахуйн нэгжүүд жилдээ хэдий хэмжээний газар ашиглаж, хэдийг нь нөхөн сэргээсэн бэ гэдэг талаарх мэдээллийг шаарддаг. Бид байгаль орчны нөхөн сэргээлтийн мэдээллийг гаргаж өгсөн. Барьцаа хөрөнгийн 50 хувийн талаарх мэдээллийг авахыг хүссэн. Энэ хөрөнгө компанийн барьцаа болгож өгсөн мөнгө, тэд хэзээ хүснэ бид түүнийг гаргаж өгөх ёстой байдаг. Барьцаа хөрөнгө бол БОАЖЯ-ны орлого биш, банкны хуулийн заалтын дагуу ил тод байлгах хориотой учраас энэ мэдээллийг бид өгөөгүй. Ямар учраас манай яамыг мэдээлэл гаргаж өгөөгүй гэж байгааг ойлгохгүй байна. Манай яам ОУИТБС-ын бүхий л ажил, хууль тогтоомжийг дэмжээд, хамтарч ажилладаг. Бид өмнөх жилүүдэд барьцаа хөрөнгийн дүнг нэгдсэн байдлаар өгсөн.

Ш.Номиндарь: Бид 40-50 орлогын урсгалыг нэгтгэх шаардлагатай. Барьцаа хөрөнгө нь орлогын урсгалын төрлийн нэг нь болж ордог учраас бид түүнийг тулган нэгтгэх шаардлагатай байдаг. Том дүнгээр өгсөн мэдээлэл дээр нэгтгэл хийх боломжгүй учраас бид нэмэлтээр мэдээлэл хүссэн. Таны хэлснээр энэ нь гаргаж өгөх боломжгүй, хууль зөрчих гээд байгаа бол тайлбараа албан ёсоор өгөх байсан. Бид албан ёсоор тайлбар аваагүй. Хэрвээ энэ нь хууль журам зөрчөөд, гаргаж өгөх боломжгүй байгаа бол ажлын хэсэг ярилцаж, шийдвэрлэх нь зүйтэй байх. Зөвхөн хараат бус нэгтгэгч авах гээд байх биш, барьцаа хөрөнгийг орлогын урсгалд оруулах уу үгүй юу гэдгийг шийдээд өгвөл сайн. Энэ тоон мэдээлэл нь тайлангийн нэгтгэлийн асуудлын хүрээнд яригдаж байгаа.

Б.Саран: Нэмж хэлэхэд энэ барьцаа хөрөнгө нь манай яамны орлого биш юм.

Ш.Номиндарь: Орлогын урсгалыг Статистикийн газраас батласан, дараа нь Сангийн яамнаас батласан байдаг. Иймээс батлагдсан орлогын урсгалыг бид хасах боломжгүй.

Ц.Батцэнгэл: Юуны өмнө 2016 оны нэгтгэл тайланг хийсэн аудитын компанидаа баяр хүргэе. Анхны зөрүү тодруулгаар тохируулаад, хөрөнгийн урсгалыг байх ёстой байранд оруулсан байна. Компани тус бүрээр нэг бүрчлэн тулгаж, тохируулсан. Манай хувьд ч гэсэн компанийн мэдээллүүд гээд нууцын хуульд хамрагдах юм байдаг, гэхдээ бид хамгийн эхэнд мэдээллээ гаргаад өгдөг, нууц гээд л өгөхгүй байвал урсгал нь доголдоно. Би хоёр дахь удаагаа тайланд оролцож байна. Зөрүү нь лицензтэй холбоотой асуудал байх. Улсын хэмжээнд түгээмэл тархацтай ашигт малтмалыг оруулаад 5000 гаруй лиценз олгосон гэдэг, ил тодын тайлангаар 2200 гаруй лиценз эзэмшигч байгаад байдаг. Багцаагаар үзэхэд лиценз авсан мөртлөө үйл ажиллагаа эхлээгүй, нэр нь байдаг, хувь хүнээр аваад сүүлдээ байгууллага болгосон гэх мэт асуудлууд байдаг. Үүнийг цэгцэлчихвэл болох байх, гол нь хүрч ажиллаж чадахгүй байгаа эрсдэлтэй хэсгээ яах вэ гэдгийг бодох хэрэгтэй байх гэж харж байна.

н.Отгонсайхан: Тайлан хийх нь амаргүй ажил. Мэдээллийг ил тод болгоно гэдэг нь төрийн бодлогоо улам чамбайруулж, тэднийг мэдээллээр хангах гэсэн зорилго байгаа. Олборлох үйлдвэрлэлийн орлогын 90 хувийг хэдхэн компани бүрдүүлдэг гэдэг. Нэгтгэл тайландаа үүнийг компаниар нь харуулчихвал илүү зүгээр санагдаж байна. Хандив тусламж, зээлээр өгсөн гэсэн мэдээлэл дээр АТГ анхаарлаа хандуулвал зүгээр юм. Тухайлбал саяхан Ланд-70 автомашиныг 170 сая төгрөгөөр хандивласан гэсэн мэдээлэл байсан, зах зээл дээр энэ машин 70,80

сая төгрөгийн үнэтэй л байгаа байх. Манай ажлын хэсгийн хуралд АТГ-аас гишүүн байдаг, тэд энэ асуудалд анхаарлаа хандуулвал бид энд суугаад, тайлан гаргаж байгаагийн хэрэг гарах болов уу.

Л.Төр-Од: Нууцлалтай холбоотой асуудал яригдаж байна, үүнд бүтээлч хандах хэрэгтэй байна, ямар нууцад хамаарч байгаа хууль зүйн үндэслэлийг тодруулах хэрэгтэй. Хэрвээ шаардлагатай бол УИХ-д хандаад төрийн нууцлалд орох жагсаалтыг эргэж харъя, олон улсын шаардлагад нийцүүлж үндэсний хууль тогтоомжоо улам боловсронгуй болгох ёстой гэсэн саналтай байна. Тайлангаа ирүүлээгүй 13 компани байна гэж байна, үүнд ямар арга хэмжээ тооцох вэ? гэсэн асуулт байна. Мөн 37 төрийн байгууллагуудаас 20 байгууллага удирдлагын захидал ирүүлсэн байна, үлдсэн байгууллагууд дээр ямар арга хэмжээ авах вэ? гэсэн асуулт байна. Зөвлөмж дээр эцсийн ашиг хүртэгч эздийн талаар яагаад зөвлөмж оруулаагүй вэ гэдэг дээр аудитын компаниас тодруулга авмаар байна. 2016 онд 50 компани бенефициар өмчлөгчийг зарласан бол энэ жил 47 компани болсон байна. Тайлангийн 24-р хавсралтыг харахад ихэнх хууль ёсны хувь нийлүүлэгч буюу хувьцаа эзэмшигч байна, түүний цаана нь байгаа жинхэнэ эзэн буюу эзэмшигчийн талаарх мэдээлэл байхгүй байна, үүнийг яаж тодруулах вэ? Төрийн өмчит компаниудаас 17 компаниас зөвхөн 7 компани ТУЗ-ын мэдээллээ өгөөгүй байна, үүнд ямар арга хэмжээ авсан талаар асуумаар байна.

Ш.Номиндарь: Бидний ажил маань олон улсын стандартын хүрээнд явагдаж байгаа. Манай улсын хувьд ашиг хүртэгч эздийг ил тод болгох асуудал илүү ахицтай, стандартын хүрээнд явж байгаа, энэ төлөвлөгөө нь 2020 он хүртэл байгаа. Тайлангийн зөвлөмж маань илүү засан сайжруулах арга хэмжээ гэдэг утгаараа орж байгаа, иймээс бенефициар өмчлөгчийн талаар ийм ажлыг засан сайжруулах хэрэгтэй гэж оруулах нь арай эрт юм болов уу. гэхдээ ажлын хэсэг маань хэлэлцээд энэ талаарх зөвлөмжийг оруулах нь зүйтэй гэж үзвэл бид оруулах боломжтой.

Н.Батбаяр: Ашигт малтмалын тухай хуулийн 48.10-т заасан үүргээ биелүүлээгүй байгаа аж ахуйн нэгжүүдийн жагсаалтыг ажлын албанаас гаргасан. ОУИТБС-ыг хэрэгжүүлэх зарим арга хэмжээг эрчимжүүлэх талаар Засгийн газрын 263-р тогтоол гарсан, үүнд манай байгууллагад 48.10-т заасан үүргээ биелүүлээгүй аж ахуйн нэгжид хуульд заасан арга хэмжээг авах үүрэг даалгавар өгсөн. Энэ нь нилээд өргөн хүрээтэй гарсан учраас төвөгтэй байдалтай байна. Хууль дээр тусгай зөвшөөрөл эзэмшигч нь дараа оны нэгдүгээр улиралд багтаан олсон орлого, төлсөн татвараа тайлагнана гэсэн байдаг. Тогтоолд тэдгээрийн туслан гүйцэтгэх аж ахуйн нэгжид гэж заасан, энэ нь жаахан хүндрэлтэй байгаа гэхдээ бид арга хэмжээ авч ажиллаж байна. Тогтоол гарснаас хойш 13 аж ахуйн нэгжид 48 сая төгрөгийн арга хэмжээ авсан. Мөн тогтоолыг хэрэгжүүлэх талаар аймаг нийслэлийн мэргэжлийн хяналтын газруудад тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллах, үр дүнг 12 дугаар сарын 1-нд ирүүлнэ. Улсын хэмжээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаарх мэдээллийг өгөх боломжтой болно.

Д.Эрдэнэчимэг: Юуны өмнө тайланг нэгтгэж гаргасан КПМЖ аудитад талархлаа илэрхийлье. Манай тайлан жилээс жилд сайжирч байгаа, ТАН эсвэл жил бүрийн тайлан гаргахад нягт хамтран ажилладаг, олон санал өгдөг. Үүнийг тайландаа тусгаж ажилладаг нь КПМЖ аудит байгаа, гэхдээ төгс юм гэж байхгүй, энэ удаагийн тайланд ч сайжруулах зүйлс их байна. Нэгтгэлийн тайланг КПМЖ хийхээр англи дээр эх нь бэлтгэгдээд, монгол хэлрүү хөрвүүлдэг. Тайланг хэнд зориулж, яах гэж гаргадаг билээ гэдгээ дандаа бодмоор байна. Англи монгол 2

хувилбарт зөрүү гарвал Англи хувийн баримтална гэсэн байна. Гэтэл монгол хэлдээр тайланг нь ойлгомжгүй, орчуулга маш муу байна. Монгол хувиа барьмаар байна, орчуулгын хувьд дэндүү модон байна. Би тайланг нилээн сайн уншлаа, ойлгоход хэцүү байна. ОУИТБС-ын цахим систем дээр байгаа мэдээллийг ашиглах гэхээр аудитаар баталгаажаагүй тул баталгаатай биш гэдэг. Харин нэгтгэл тайлангийн мэдээллийг баталгаатай гэж үзэж, иргэний нийгэм бусад байгууллагууд ашигладаг. Гэтэл удиртгал хэсгээсээ эхлээд энэ мэдээлэл найдвартай биш, энэ мэдээлэлд үндэслэсэн хэрэглэгч өөрөө хариуцлагаа хүлээнэ гэх мэтээр бичсэн байна. Иймээс ямар мэдээллийг найдвартай гэж үзэх вэ? Бид яах гэж энэ тайланг гаргаад байна вэ? гэсэн асуудал байна. Ер нь хараат бус хянан нэгтгэгч ажлын даалгаврын хүрээнд ажиллаж байгаа байх, гэхдээ ажлын хэсгээрээ энэ талаар ярилцах нь зүйтэй байх. Тайланд өгөх олон санал байна. Ялангуяа зөвлөмжтэй холбоотой. Цаг бага байна гэж яаруулаад байгааг ойлгохгүй байна. Яагаад заавал ийм чухал асуудлыг хоёрхон цагт ярих ёстой юм, яагаад бүтэн өдөр гаргаж болохгүй байна вэ? Ажлын хэсэг жилд 2-3 хан удаа хуралддаг байж гол асуудлаа хэлэлцэхэд цаг гаргах хэрэгтэй. Олон санал байна, засах янзлах юм их байна.

Б.Энх-Амгалан: За танд баярлалаа, саналаа цаг хэмнэх үүднээс бичгээр өгчих.

Д.Эрдэнэчимэг: Саналаа бичгээр өгөхөөр дараа нь миний саналыг тайланд оруулсан эсэх талаарх саналыг хэлэлцэх хурал бас хийх хэрэгтэй болох байх

Б.Энх-Амгалан: тэр болно, бид энэ аудитын компаниар тайлан гаргаад тодорхой хэмжээний хөлс төлж байгаа. Одоогоор энэ нь гаднын эх үүсвэрээр явж байгаа. Тайлан гэж бодь ном шиг юм гаргаад, түүнийг цөөн хүн уншиж, хэрэглэж байгаа бол үүний утга агуулга нь бага болж байна. Нэгэнт бид мөнгө төлөөд хийлгэж байгаа юм чинь Засгийн газар, төр, иргэний нийгмийн байгууллагууд бүгдээрээ гарын авлага болгож явдаг, хүн болгон хэрэглэж болохоор хялбар бичиг баримт байх нь зөв байна. Иймээс гишүүд тайланд оруулах саналаа бичгээр ажлын хэсэг дээр өгөөд, ажлын алба нэгтгээд тайланд оруулах арга хэмжээ авахаар хурлын шийдвэрт оруулъя. Уул уурхайн компаниуд ялтай муу ажил хийгээгүй, мэдээлэл авах арга хэрэгсэл нь соёлтой баймаар байна. Компаниуд мэдээлэл тайландаа хамрагдаад явбал тэдэнд хандах хардлага, муу хандлага нь өөрчлөгдөнө гэдгийг ойлгуулмаар байна. Гарч байгаа мэдээлэл стандарт тайлан байгаад дараа нь үнэн зөв, бодитой, хялбар төсөр хувилбарыг гаргамаар байна. Зураг, график, динамик хэлбэрээр ойлгомжтой, хамгийн энгийн хэлбэрээр бэлтгэвэл зүгээр байна.

Мэдээллийн хувьд айхтар хувь хүний нууцтай холбоотой биш бол гаргаад өгчихмөөр байна. Мэдээллийг авахдаа соёлтой, зөвшөөрөгдсөн хэм хэмжээнд ажилламаар байна. Төрийн байгууллагаас төрийн байгууллагуудад хандаж, мэдээлэл ирүүлж, үүргээ биелүүлэх талаар албан бичгийг явуулъя. Тайлангаар гарсан дүнг Засгийн газарт оруулаад тэмдэглүүлчихвэл тэр маань бидний гарын авлага болж, ашиглагдах боломжтой болно. Аудитын компанийн ажлын хөлс 60 хувийг төлж барагдуулах тухай шийдвэрийн төслийг дэмжих үү, гарсан саналуудыг оруулаад.

Д.Эрдэнэчимэг: Бичгээр өгөх саналаа хэдийд багтаж өгөх вэ, тэр саналыг хэзээ батлах товоо тогтвол сайн байна. Мөн нууц гээд байгаа зүйлүүд нь үнэхээр нууц юм уу, хууль эрхзүйн үндэс нь юу байна гэдгийг судлах ажлын хэсэг гаргая.

Яагаад гэвэл энэ дүгнэлтийг хараат бус хянан нэгтгэгч хийдэггүй, бид жил бүр энэ талаар санал гаргадаг. Тодорхой асуудлаар дүгнэлт хийж, зөвлөмж өгөөч гэсэн санал гаргадаг. Харин хянан нэгтгэгч бид хууль тогтоомж, зөрил зэрэг асуудлаар дүгнэлт хийх боломжгүй гэсэн хариу өгдөг. Хэрэв хянан нэгтгэгч дүгнэлт хийж болдоггүй юм бол Ажлын хэсэг өөрсдөө иймэрхүү асуудлуудыг судалж, дүгнэлт, шийдвэр гаргах хэрэгтэй.

Байгаль орчны нөхөн сэргээх барьцаа хөрөнгийн талаарх мэдээлэл нууц байх уу? Бид компанийн дансны мэдээллийг хүсээгүй, зөвхөн БОАЖЯ-ны дансанд төвлөрсөн хөрөнгийн мэдээллийг хүссэн. Харилцагчийн нууц гэдэг юм энд хамаарахгүй, иймд үүнийг тогтоох ажлын хэсэг байгуулмаар байна.

Б.Энх-Амгалан: Хэрвээ үнэхээр компанийн нууцад халдах гээд байвал болохгүй, гэхдээ манай мэдээллийн хувьд компанийн нэрийн ард хэдэн төгрөг гэдгийг тавиад өгөхөд нууцад халдсан болохгүй байх. Ингээд энэ асуудлыг дуусгая. Бичгээр өгсөн саналыг ирэх долоо хоногт ажлын хүрээнд шийдвэрлэе.

Ш.Номиндарь: Жил бүр ТАН эвслээс зөвлөмжүүд гардаг, бид боломжтой асуудлыг тайланд оруулдаг. Бид гурван талаас зөвшөөрөгдөж, нэгтгэгдсэн саналыг бидэнд явуулахыг санал болгож байна. Санал маань ажлын хэсгийн санал байх ёстой, бусад талууд иргэний нийгмийн саналыг дэмжсэн тохиолдолд бидэнд ирүүлнэ, стандартаараа ийм байгаа.

Д.Эрдэнэчимэг: Ажлын хэсгийн хурал дээр хэлж байгаа санал дээр дахин санал хураах ёстой юм уу? Тэгвэл гаргасан саналыг дэмжиж, эсвэл дэмжихгүй байгааг нэг дор шийдээд явахын тул одоо саналаа хэлмээр байна.

Т.Амарзул: Төлбөрийн талаар тодруулъя, 60 хувь нь гэрээний дагуу хийгдэж байгаа гэсэн үгүү, тайлан батлагдсан гэж төлж байгаа юм уу?

Ш.Цолмон: Энэ ажил нь нийт 190 сая төгрөгний гэрээтэй, улсын төсвийн хөрөнгөөр хийгдэж байгаа ажил. Гэрээ хийхэд урьдчилгаа 30 хувь, одоо Ажлын хэсгийн хурлаар батлаад 60 хувь, үлдэгдэл төлбөрийг Үндэсний зөвлөлийн хурлаар батлаад, зөвшөөрсөн тохиолдолд төлөх ёстой, зөвлөх үйлчилгээний ажил юм.

Ш.Номиндарь: Тайлангийн хураангуй хэлбэрээр бэлтгэх нь манай ажлын цар хүрээнээс гадуур байгаа. Жил бүр ТАН эвсэл энэ хүсэлтийг гаргадаг, тайлан гаргах нь маш их цаг хугацаа, хүн хүч шаардсан ажил болдог. Иймд хийх боломжгүй юм, харин дараа жилийнхээн ажлын даалгавартаа тусгаад оруулчихвал бид гэрээний хүрээнд, хүлээсэн үүргийнхээ дагуу хийх боломжтой. Нэг тодруулга хэлэхэд, манайх 70 гаруй ажилтантай, Монголд үйл ажиллагаа явуулдаг Монгол компани, гадаад байгууллагын салбар компани юм.

Б.Энх-Амгалан: Бид төлбөрөө төлөөд захиалгат ажил хийлгэж байгаа. Танайхыг Монгол компанигэж үзэж байгаа шүү.Тиймээс чанартай, үнэн зөв бүтээгдэхүүн гаргуулах хүсэлтэй.

**2.ХЭЛЭЛЦСЭН нь: Ашиг хүртэгч эздийг ил тод болгохтой холбоотой хууль эрхзүйн ойлголтын тодорхойлолтын талаарх танилцуулга**

Б.Дэлгэрмаа: Миний бие ашиг хүртэгч эздийг ил болгох ажлын хэсгийн нарийн бичгээр гаргасан, Нээлттэй нийгэм форумын ажилтан Эрдэнэчимэг маань

дэмжлэг үзүүлэн ажилласан байгаа. Замын зураг маань 2020 он гэхэд ашиг хүртэгч жинхэнэ эздийг ил болгоно гэж заасан.

Нийтдээ энэ ажлын хүрээнд есөн удаагийн хэлэлцүүлгийг зохион байгуулж, төрийн байгууллага, иргэний нийгэм, компанийн 260 гаруй хүмүүсийг хамрагдаж, саналыг нь авсан. Энэ 9 хэлэлцүүлгээс гарсан нэр томъёог та бүхэнд танилцуулж байна.

Бенефициар гэдгийг ашиг хүртэгч жинхэнэ эзэн гэсэн хувилбар оруулсан бол сүүлийн байдлаар ашиг хүртэгч жинхэнэ эзэн гэсэн нэр томъёог дэмжсэн. Сүүлийн хувилбар нь ашиг хүртэгч эцсийн эзэн гэсэн хувилбар гарсан. Жинхэнэ эзэн гэдэг нь хуурамч эзэн байдаг мэтээр ойлголт төрүүлж байна. Иймд эцсийн эсвэл Ашиг хүртэгч гэсэн байдлаар томъёолох, хоёрдугаарт хянагч гэсэн утга агуулга шингэсэн байх ёстой гэсэн санал гарсан. Эцсийн эзэн нь ашиг хүртэгч эзэн биш байх тохиолдол олон байдаг тул дэмжээгүй. Owner гэдэг үг нь өмчлөгч, эзэмшигч гэсэн утгатай тул утгыг алдагдуулахгүйгээр хэрэглэх санал гарсан. “Ашиг хүртэгч эцсийн эзэн” гэдэгт эрдэс баялагийн салбарт тусгай зөвөөрөл эзэмшигч, хөрөнгө оруулагч, тендерт оролцогч, гэрээлэгч хуулийн этгээдийн удирдлага, хяналт, хөрөнгийн эрхийг шууд болон шууд бусаар хэрэгжүүлдэг, ашиг хүртэгч хувь хүнийг ойлгоно. Хэлэлцүүлгээс гарсан саналуудыг та бүхэнд нэгтгэн санал болгож байна.

Өнөөдрийн хуралдаанаар ашиг хүртэгч эздийг ил болгох ажлын төлөвлөгөө буюу замын зургаа өөрчилж, санал авах ёстой. Замын зураг дээр улаанаар тэмдэглэсэн байгаа өөрчлөлтийг танилцуулъя. УИХ-ын гишүүд Засгийн газрын байгууллагуудын дунд дугуй ширээний ярилцлага зохион байгуулах ажлын ЕСБХБ-ны санхүүжилтээр хийгдэхээр хүлээгдэж байна.

Холбогдох хуулиудад өөрчлөлт оруулах хуулийн төслийн боловсруулах, өргөн барих ажлын мөн ЕСБХБ дэмжлэг үзүүлэх болсон. Сангийн яамнаас хэд хэдэн хуулийн нэр томъёонд өөрчлөлт оруулах талаар төсөл явж байгаа гэсэн, бид ажла хооронд нь уялдуулах хэрэгтэй байх. Гуравдугаар зорилтын ажлууд бүгд хийгдсэн. Олон нийтийн мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх замаар ашиг хүртэгч эздийг ил болгох компанид чиглэсэн нөлөөллийн ажил зохион байгуулах зорилтын хүрээнд ЕСБХБ-ны санхүүжилтээр сургалт, хэлэлцүүлгийг зохион байгуулна. Мөн зорилт 6, 7-ийн хүрээнд хэд хэдэн ажлын хийхэд дэмжлэг үзүүлэхээр болсон, замын зурагт орсон өөрчлөлтийг улаанаар тодруулсан байгаа тул та бүхнийг танилцаад саналаа өгөхийг хүсье. /Танилцуулгыг хавсаргав/

Б.Энх-Амгалан: За баярлалаа, Хууль зүйн яаманд хуулийн зөвлөл байгаа, ЗГХЭГ-т хуулийн хэлтэс байгаа, дараа нь УИХ-аар орно гээд олон шүүлтүүрээр орно. Манай ажлын хувьд олон улсын байгууллагынхаа өмнө хүлээсэн үүргийнхээ дагуу холбогдох юмнуудаа хийгээд өгье. Яг нарийндаа би Киргизид ажиллаж байгаад ирсэн, тийм их жишээ авахаар сайхан орон биш. Таны хийсэн ажлыг үнэлж байна, баярлалаа. Энэ хуулийн төслийг Хууль зүйн яаманд явуулах саналтай байна.

Д.Эрдэнэчимэг: Хууль зүйн яам хэзээ ч биднээс тодорхойлолт аваад, дүгнэлт гаргаж өгөхгүй. Бид замын зурагтай байгаад, эхлээд нэр томъёоны тодорхойлолтоо ажлын хэсгээр зөвшилцөж, баталчихаад, түүнийгээ аль хуульд оруулахыг хуулийн санал болгон боловсруулчихаад, журмын дагуу Хууль зүйн яамнаас санал дүгнэлт авах ёстой. Иймд тодорхойлолтыг ажлын хэсгийнхэн зөвшөөрч байна уу гэдгийг л одоо шийдсэн нь дээр.

Т.Наранзаяа: Ер нь хууль нь батлагдлаа гэж үзье. Манай иргэдийн сэтгэлгээ хэцүү, уул уурхай руу дайрдаг, хамаг баялагийг цөлмөөд өөрсдөө баяжаад байна гэх мэтээр хэлдэг. Ер нь газар доорх баялаг маань ил гарч байж баялаг болдог. Иймээс иргэдийн сэтгэлгээний хөрсийг яаж сайжруулах вэ? уул уурхай гэдэг нь хэрэгтэй, бид ашигласнаар ингэж сайжирна гэдгийг ойлгуулах хэрэгтэй. Төр засгийн зүгээс ч арга хэмжээ авах шаардлагатай байх.

Б.Энх-Амгалан: За баярлалаа, Ер нь бол төрийн албан хаагч уурхайн эзэн байж болох уу гэдэг талаар ярьж байна.

Д.Эрдэнэчимэг: Байж болно, гэхдээ ил байх ёстой. Бид жилдээ 1,2 удаа л хуралдаж байгаа, яагаад заавал ингэж яаруулаад байгааг ойлгохгүй байна.

Б.Энх-Амгалан: Энэ нь олон улсын байгууллагын өмнө хүлээсэн үүргийнхээ дагуу бидний зүгээс боловсруулсан төсөл юм.

Б.Дэлгэрмаа: Үүнийг ажлын хэсгээс боловсруулаагүй, 260 гаруй төр, компани иргэний нийгмийнхэн бодож, шүүлтүүрээр орсон цар хүрээ хэм хэмжээ байгаа. Үүнийг батлахад Сангийн яам, Уул уурхайн яамны төлөөллүүд байсан учраас энэ тодорхойлолт нь эцсийн тодорхойлолт юм гэдгийг цааш нь төрийн байгууллагуудад мэдээлж өгөхийг хүсэж, энэ шугамаар шийдвэр гаргуулах гээд байгаа. Мөн замын зураг дээр ЕСБХБ-наас санхүүжүүлэх ажлуудыг оруулсан. Үүн дээр бид саналаа өгчихвөл ажлууд эхлэх гээд хүлээгдээд байгаа. Энэ хоёр асуудлаар шийдвэр гаргуулах хэрэгтэй байна.

Б.Энх-Амгалан: За баярлалаа, ажлын хэсгээс гарсан саналыг дэмжиж байгаа гишүүд гараа өргөнө үү.

Д.Эрдэнэчимэг: Бид гишүүдээс санал авахгүй бол болохгүй, энэ чинь том хариуцлага.

Д.Энхболд: Бусад гэдгийг авах юмуу? Эсвэл илүү тодорхой томъёолж болохгүй юу?

Б.Дэлгэрмаа: Бусад хэлбэрээр гэдэгт хувьцаагаар биш, саналын эрхээр биш шууд ТУЗ-ыг томилдог, чөлөөлдөг ч юм уу, нөлөөлдөг этгээд ч гэдэг юм уу тодорхой болгох уу?

Д.Эрдэнэчимэг: Нөлөөллийн бусад хэлбэрүүд гэдэгт гэрээгээр, хувьцаагаар, итгэмжлэхээр зэрэг хэлбэрүүд байдаг. Үүнээс гадны бидний мэдэхгүй нууц хэлбэрүүд байдаг. Бид ил болгож чадахгүй байгаа, цаана байгаа эзнийг ил болгох гээд байгаа учраас бусад гэдэг байдлаар орсон.

### **3.ХЭЛЭЛЦСЭН нь: Ажлын хэсгийн ажиллах журамд нэмэлт өөрчлөлт оруулах тухай**

Ш.Цолмон: ОУИТБС-ын Удирдах хорооноос өгсөн зөвлөмжийн дагуу нэмэлт өөрчлөлтийг оруулж байна. Монголын ОУИТБС-ын Ажлын хэсгийн ажиллах журмыг анх 2006 онд баталсан, 2012 онд нэмэлт өөрчлөлт оруулж, одоо энэ журмыг дагаж мөрдөж байна. ОУИТБС-ын Удирдах хорооноос стандартын дагуу 2016 онд “Баталгаажуулалт” хэмээгдэх олон улсын хөндлөнгийн чанарын үнэлгээгээр манай улс 7 төрлийн нэмэлт ажил хийж, 2018 оны 1 дүгээр сард дахин

үнэлгээнд орох зөвлөмж болгосон юм. Үүнд, Ажлын хэсэг, Үндэсний зөвлөлтэй холбоотой буюу энэ 2 бүтцийн гишүүдийн хуралдааны ирц, санал хураалт, оролцогч талууд төлөөллөө сонгох, ажиллуулах журмуудыг шинэчлэх тухай юм. Засгийн газрын төлөөлөл нь Ерөнхий сайдын захирамжаар томилогддог бөгөөд саяхан Ерөнхий сайдын 2017 оны 9 дүгээр сарын 20-ны өдрийн 142 тоот захирамжаар шинэчлэгдсэн байна. Компани, Иргэний нийгмийн байгууллагууд өөрсдөө төлөөллөө сонгодог тул уг зөвлөмжийн дагуу журмаа шинэчилж, шинэ журмын дагуу сонгон шалгаруулалтаа явуулж, шинэ бүрэлдэхүүнээ шинэ оноос өмнө томилсон байна.

Зөвлөмжийн дагуу журамд дараах нэмэлт өөрчлөлтийг оруулах саналтай байна. Үүнд:

1. Ажлын хэсгийн нийт гишүүдийн тоо 33 буюу оролцогч тал бүр тэнцүү 11 төлөөлөлтэй байдаг. Хуралдаанд ирсэн байвал зохих гишүүдийн тоог оролцогч бүрээс хамгийн багадаа 6 гишүүн ирсэн байвал хуралдааныг хүчинтэйд тооцох саналыг оруулж байна. Өөрөөр хэлбэл, 3 тал бүрээс хамгийн багадаа 6 хүн буюу нийт 18 гишүүн байхаар санал болгож байв. Өмнө нь энгийн олох буюу 17 хүнээр тооцож ирснийг ингэж өөрчлөх саналтай байна.
2. Зөвлөмжийн дагуу шийдвэр гаргахад санал зөрөлдөх тохиолдолд санал хураах боломжийг нээж байгаа бөгөөд үүгээр санал хурааж, шийдвэрийн хүчинтэй байх дүн нь тухайн асуудлаар хуралдаанд оролцсон төлөөлөл бүрийн 2/3- оос доошгүй тооны гишүүдийн санал авсан байх ёстой.

Иймд энэ 2 саналыг баталж өгөхийг хүсье. Үүний дагуу Үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүнд мөн өөрчлөлт орох ёстой. Ажлын хэсэгт ажилладаг нилээд байгууллагууд Үндэсний зөвлөлд ордог байгаа. Иймд үүнийг цогцоор өөрчлөх нь зүйтэй болов уу?

Н.Наранцэцэг: Нэг оролцогч талаас 6 хүн байж хурал хийнэ гэсэн үг үү?

Ш.Цолмон: Тийм, хамгийн багадаа 18 гишүүнийн бүрэлдэхүүнтэй, нэг талаас доод тал нь 6 гишүүн байж хурал хүчинтэй болно гэсэн үг, өөрөөр хэлбэл пропорцоо хангаж байгаа.

Н.Наранцэцэг: Ер нь иргэний нийгмийн гишүүд бараг бүгдээрээ оролцдог, хөдөө орон нутагт ажиллах тохиолдолд ирж амжихгүй байх. Төрийн байгууллагын хувьд ирцийн талаар яригдах байх. Ирсэн нэг нь бүртгүүлчихээд, нээлт хийчихээд гараад явчихдаг, тогтвортой суугаад хуралдаа оролцож чаддаггүй. Асуудал хэлэлцээд шийдвэр гаргахад иргэний нийгэмийнхэн л байдаг. Компанийн төлөөлөл бас бага байдаг, оролцдог цөөн компани байдаг. Төрийн байгууллага журмаа баримтлавал иргэний нийгмийн зүгээс асуудал байхгүй.

н.Мэндбаяр. Компанийн төлөөллийг үг хэлэх боломж олгохгүй байна. Төрийн өмчийн компаниуд мэдээллээ дутуу гаргасан. Өмнө жил ч ийм асуудал гарч байсан.

Бид энэ жил 2 удаа сургалт хийсэн, ийм асуудал гарч л байна. Дараа жил бас л гарна. Гэхдээ хариуцлага тооцох механизм гаргачихвал арай үр дүнтэй болох байх. Сургалт зохион байгуулахаар жинхэнэ суух ёстой хүмүүс нь ирдэггүй, дараа жил нь дахиад л ийм юм болно.

Б.Энх-Амгалан: Гурван талын оролцоо хамгийн багадаа зургаа байж хурал эхлэхээр журамд өөрчлөлт орж байна, үүнийг дэмжих үү?

Н.Наранцэцэг: Нэг талаас зургаа гэсэн гээд нэг нэгэндээ найдаад байх вий. Манайханд тийм асуудал байдаг шүү. Хурал хуралдаад шийдвэр гардаггүй болчихвий гэж эмээж байна.

Б.Энх-Амгалан: Манай байгууллага Их хурал, Засгийн газрын хуралдаан биш, нийгмийн байдалд нөлөөлөх тийм асуудал гайгүй байх, харьцангуй бодлогын шинжтэй зөвлөмжүүд гарна. Ингээд журмын өөрчлөлтийг дэмжиж байгаа хүмүүс гараа өргөнө үү.

#### **4.ХЭЛЭЛЦСЭН нь: ОУИТБС-ын 2017 оны ажлын төлөвлөгөний биелэлтийн явц, 2018 оны ажлын төлөвлөгөөний төслийн танилцуулга**

Ш.Цолмон: За баярлалаа, 2017 онд нийт 76 үйл ажиллагааг ажил хийхээр төлөвлөснөөс одоогийн байдлаар 39 үйл ажиллагааг хэрэгжүүлээд байна. 2017 он дуусаагүй байна, үлдсэн хугацаанд ажиллана. Энэ онд Ажлын хэсэг 3 дахь удаагаа хуралдаж байна, дэд хэсэг 2 удаа хуралдсан. Өнөөдөр 2016 оны тайланг хэлэлцлээ, цаашид ажиллах шаардлага их байна. Хийгдсэн томоохон ажлуудыг дурдвал, энэ жил 1167 компани, Засгийн газрын 11 байгууллага, 7 агентлаг, 9 дүүрэг, 15 аймаг тайлан гаргасан байна. Сангийн яамны гаргаснаар олборлох салбарын орлого 1,2 их наяд төгрөг байна гэж нотолсон. 2017 оны 2,6 дугаар сард шийдвэр гаргаад Засгийн газрын 222-р тогтоолд өөрчлөлт оруулсан байгаа. Үүнд, ОУИТБС-ын олон улсын стандартыг бүрэн хүлээн зөвшөөрч хэрэгжүүлэх, ашиг хүртэгч эздийг ил тод болгох хуулийн төслийг УИХ-д өргөн барих тухай заасан. 2019 оноос эхлэн дэд зөвлөлийн ажиллагааны зардлыг улсын болон орон нутгийн төсвөөс шийдэх болсон зэрэг асуудлууд байгаа. Бид хууль эрхзүйн эмхтгэлийг дахин хэвлэсэн. Төрийн өмчит компанийн сургалтын Эрдэнэс монгол компанитай хамтран зохион байгуулсан, 9 удаагийн хэлэлцүүлэг хийсэн. Хөдөө орон нутагт Ерөө, Заамар, Бор-Өндөр, Гурван тэс, Дэлгэрэх сумдад ЕСБХБ-ны санхүүжилтээр жишиг сум байгуулах төсөл амжилттай хэрэгжиж байна. Орон нутгийн иргэдэд мэдээлэл өгөх, зөв ойлголттой болох, Эрдэс баялагийн салбарт төрөөс баримтлах бодлого, Засгийн газрын 222-р тогтоолыг хэрэгжүүлэхэд энэ ажил чухал учраас хөдөө орон нутагт чиглэн ажиллаж байна. Үндэсний хөгжлийн газартай хамтран орон нутгийн төлөвлөлтийн семинар зохион байгуулсан. Гэрээний ил тод байдлын хүрээнд цахим санг байгуулсан. Үүнд Нээлттэй нийгэм форум дэмжлэг үзүүлэн ажилласан. УУХҮЯам, Нээлттэй нийгэм форум манай ажлын алба хамтран ажиллах санамж бичиг байгуулсан.

Үлдсэн хугацаанд Үндэсний зөвлөлийн хурлыг зохион байгуулна. Өнөөдрийн хурлаар гарч байгаа шийдвэрүүдийн дагуу нилээдгүй ажил зохион байгуулж, хэрэгжүүлнэ. Бид 2018 оны 1 дүгээр сард олон улсын баталгаажуулалтад орж, үнэлгээ авна. Иймээс та бүхнийг ажлаа зохицуулан идэвхтэй оролцохыг хүсье.

2018 онд хэрэгжүүлэх ажлын хүрээнд дөрвөн зорилтыг тавьсан. Үүнд, ОУИТБС-ын Олон улсын баталгаажуулалтаар өгсөн зөвлөмж, Монгол улсын 2016 оны нэгтгэл тайлангаар өгсөн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлэх, ОУИТБС-ын 2017 оны тайлангийн нэгтгэлийн явцыг сайжруулах, тайлан хэлэлцэн батлах, Үндэсний болон орон нутгийн түвшинд ОУИТБС-ыг хэрэгжүүлсний нөлөө, ач холбогдлыг талуудад таниулан сурталчилах, хамтын ажиллагааг сайжруулах, ашиг хүртэгч

жинхэнэ эздийн ил тод байдлыг хангахад чиглэсэн эрхзүйн орчинг бүрдүүлэх, мэдээлэл бүртгэлийн тогтолцоог сайжруулах ажлын хүрээнд олон ажлуудыг хийхээр төлөвлөсөн. Тухайлбал, Үндэсний түвшний мэдээлэл харилцааг идэвхжүүлэхэд чиглэсэн телевизийн цуврал нэвтрүүлэг, шууд хэлэлцүүлгийг ЗГХЭГ-ийн хэвлэл мэдээллийн албатай хамтран зохион байгуулахаар төлөвлөсөн. Одоо гарч байгаа тайлан мэдээллийг бодит аль болох ашиглагдахгүйц, хэрэглэгдэхгүйц байхын төлөө энэ ажил чиглэнэ. Ажлын төлөвлөгөөг урьчилан тараасан байгаа, санал байвал өгч болно. Ажил хэрэгч, хэрэгжихүйц ажлыг санал болгон хамтран ажиллахыг хүсч байна.

Б.Энх-Амгалан: Одоо 4,5 дугаар асуудлыг хамтад нь сонсоод, дараа нь гишүүд саналаа хэлээд явчихвал болох уу.

Ш.Цолмон: Тавдугаар асуудал нь явцын танилцуулга юм.

Б.Дэлгэрмаа: Танилцуулга хийх компани арай ирээгүй байна.

Б.Энх-Амгалан: За тэгвэл гишүүд саналаа хэлье, Нэг хүн 3 минут

Б.Саран: 2018 оны төлөвлөгөөтэй холбоотой санал байна. Засгийн газрын тогтоол байгаа, манай яамнаас 2006 оноос хойш тавьж байгаа нэг хүсэлт байдаг, үүнийг сайжруулах чиглэлээр 2018 оны төлөвлөгөөнд тусгаж өгөөч. ҮАГ-ын сургалтыг манай яамтай хамтатгаж хийж өгөөч. Жил бүр тайлангийн чанар муу байна гэж ярьдаг. Энэ тайланг татвар төлөгч байгууллагын төсвийн хөрөнгөөр хийдэг, иймээс төрийн байгууллага аж ахуйн нэгжүүдийн хэрэгцээ шаардлагыг хангасан тайлангийн стандарттай болмоор байна. Тайланд тавих шаардлага байх хэрэгтэй байна үүнийг бас төлөвлөгөөнд оруулмаар байна. Олон сургалтууд хийгддэг, энэ сургалтыг гүйцэтгэлийг сайжруулах чиглэлээр ажлын гүйцэтгэлтэй холбоотой зорилтот сургалтуудыг хиймээр байна. манай яам ОУИТБС-ын ажилд нэг номерт явж байх ёстой гэдгийг ойлгож байна, тайланд дурдсан мэдээ тайлан өгөөгүй гэдгийг засуулмаар байна.

Н.Батбаяр: Аж ахуйн нэгж байгууллагуудын тайлан гаргаж байгаа байдал хангалтгүй байна. 4000 гаруй хатуу ашигт малтмалын тусгай зөвшөөрөл байдаг. Газрын тосны бүтээгдэхүүн хуваах гэрээ байгуулсан компани 30 орчим, түгээмэл тархацтай ашигт малтмал ашиг тусгай зөвшөөрөл авсан аж ахуйн нэгж 1000 орчим нийтдээ 5000-аад лиценз байна. Энэ чиглэлээр соён гэгээрүүлэх ажил хийгдэхгүй байна, энэ талаар ажил төлөвлөж төлөвлөгөөндөө оруулах хэрэгтэй байна. Бид Засгийн зарын 263-р тогтоолын дагуу 4000 орчим аж ахуйн нэгжид арга хэмжээ авахаар болоод байна.

Торгуулийн хэмжээ доод тал нь 3 сая түүнээс дээш 10 сая хүртэлх төгрөг байна. Энэ торгуулах мөнгөөрөө аж ахуйн нэгжүүд нийгмийн сайн сайхны төлөө ажил хийвэл өөрсдөд нь хэрэгтэй юм. МХЕГ нь зөвхөн торгодог, шийтгэдэг гэдэг муу нэг хүлээх нь хэцүү байна. Иймээс хууль сурталчилах ажлыг хийх хэрэгтэй байна.

Ж.Батцэнгэл: Миний санал Батбаяр даргын саналтай давхардлаа, иймээс энэ талаар төлөвлөгөөнд оруулмаар байна. Мөн жил бүр яриад авч чадахгүй байгаа программ хангамжаа авмаар байна. Дэлхий нийтийн хэмжээнд сүлжээ байдаг юм байна. Хэрвээ хөрөнгө мөнгө нь байдаг бол энэ ажлын зохицуулах санал байна.

Б.Энх-Амгалан: Бид 2018 онд улсын төсвөөс 243 сая төгрөг, Дэлхийн банкнаас 284 сая төгрөг нийтдээ 530 сая төгрөгийн боломж байна, үүнийхээ хүрээнд ажлаа төлөвлөх хэрэгтэй байх.

Ш.Отгонсайхан: Орон нутагт дэд зөвлөлөө сайн ажиллуулвал, мөнгө хэмнэх боломж байна.

Б.Энх-Амгалан: Дараа жил дахин сонгон шалгаруулах уу, хэдэн төгрөгөөр хийлгэх бол тал нь явчих уу? Гайгүй газраар шахаж байгаагаад сайн тайлан хийлгээд авчихвал, дараа нь зүгээр байх.

Т.Мөнхбат: Байгууллагуудаас мэдээлэл авах хэцүү байдаг байх. Байгууллагууд хуулийн хүрээнд л ажлаа хийж байгаа. Хэрвээ ажлын шаардлагаар компаниудын мэдээллийг авах бол түүнд зөв гаргалгаа хийж байж мэдээлэл авах хэрэгтэй. Оюутолгой компанийн хувьд аль болох түргэн шуурхай мэдээллээ гаргаж өгдөг, гэхдээ хуулийн дагуу нууцын тухай хуулиа зөрчихгүй байх ёстой байх. Олон компаниуд мэдээллээ өгөхгүй байна. Манай энэ салбарын сүүдэрийн эдийн засаг гэдэг юмуу нөхөрлөлүүд, бичил уурхай эрхлэгчид хаана яваад байна, бүртгэлд орж байна уу, тэд маш их олборлолт хийж байдаг, цаашдаа эд нарын мэдээллийг авч байх шаардлагатй, аюулгүй байдлыг хангаж ажиллахгүй байгаа тохиолдолд тэдний үйл ажиллагааг хориглох хэрэгтэй. Энэ байгууллагууд жишээлэхэд, их алт олборлож тушаадаг, хамгийн ихээр байгалийг сүйтгэж, уул уурхайн салбарын нэр хүндийг унагааж байгаа. Энэ бичил уурхай эрхлэгч 70 гаруй мянган иргэд татвар төлдөг эсэх мэдээг илүү тодорхой болгоно уу.

Б.Энх-Амгалан: За баярлалаа, гарцаагүй чухал саналыг хэллээ.

Т.Амарзул: 2017 оны ажлын төлөвлөгөөний биелэлтийг харахад төсөв хэмнэгдсэн юм шиг харагдаж байна, энэ хэмнэсэн мөнгийг тайланг арай өөр хялбараар хийх ажлыг нэмэлтээр төлөвлөгөөндөө тусгаж болох уу? 2018 оны төлөвлөгөөний зорилт 5-д Бүтээгдэхүүн хуваах гэрээг ил тод болгох ажлын оролцогч талуудад компанийн төлөөллийг яагаад оруулаагүй юм бол? гэсэн асуулт байна. ОУИТБС-ын тайлан нь гадаадын хөрөнгө оруулагч нарт томоохон мэдээлэл болж өгдөг. Иймд тайлангаа англи хэл дээрээ гаргаад, орчуулгаа сайжруулаад явах нь зүйтэй байх. Мэдээллийг ил тод болгосноор гарах эрсдэлийг тооцсон уу, мэдээллийг буруу ойлгох, буруугаар ашиглах, хүнийг дарамтлах гэх мэтээр гарах эрсдэлийн талаар ярих ёстой болов уу?

Ш.Цолмон: Төлөвлөгөөний тухайд уг нь компанийн төлөөлөл байх ёстой, техникийн алдаа гарсан байх. Эрсдэлийн тухайд ямар ч зүйл гарахыг үгүйсгэхгүй, ямар ямар хуулиудаар ил тод байдлыг зөвшөөрдөгийг, тэр хуулиа баримтлахыг зөвлөдөг. Ямар ч тохиолдолд аль нэг оролцогчын талд орохгүй байх нь сөрөг хандлагыг багасгадаг. Ер нь энэ ажил нь Дэлхийн санаачилга, 53 орон нэгдээд байгаа Иран, Афганистан зэрэг дайн байлдаантай орнууд хийх гээд зорьж байгаа. Тэрнийг бодвол манай орон харьцангуй гайгүй. Олон улсын газраас хэрвээ эвлэлдэн нэгдээд үүнийг хийж байгаа бол өөрсдөө эрсдэлээ хариуцаад явах, чадахгүй бол заавал хийх албагүй гэдгийг хэлдэг. Аль болох зөв ойлгуулах замаар ажиллах нь зүйтэй.

Л.Төр-Од: 2017 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд Эрдэс баялагийн ил тод байдлын тухай хуулийн төслийг УИХ-д өргөн барих гэсэн ажил байсан. Үүнийг Уул уурхайн хуулийн төсөлд бүлэг болгон оруулахаар явж байгааг би буруу гэж үзэж

байна. Хариуцлага тооцох асуудал ОУИТБС-ын хэрэгжүүлэх явцад дутагдаад байгаа. Эрдэс баялагийн ил тод байдлын тухай хуулиар энэ санаачилгаа тогтолцооны хувьд бэхжүүлж, хариуцлага тооцох боломжтой болно, үүнийг орхигдуулж болохгүй. Энэ хуулийн төслийн УИХ-д өргөн барьснаар төрийн нууцын тухай, байгууллагын нууц, банкны нууцын тухай хууль холбогдох хууль тогтоомжуудад өөрчлөлт оруулснаар мэдээлэл өгөөгүй төрийн болон төрийн өмчит байгууллагуудад хариуцлага тооцох боломжтой болно. Мөн орон нутгийн дэд зөвлөлүүдийг үйл ажиллагааг идэвхжүүлж, ашиглах. Бүх яам агентлаг орон нутгийн хяналтын зөвлөлийг байгуулсан. Энэ зөвлөлүүдийг санаачилгаа хэрэгжүүлэхэд дайчлан ажиллаж болно. Төсөв нь Хууль зүй дотоод хэргийн яаманд байгаа. Санаачилгыг хэрэгжүүлэхэд хандивлагч, доноруудтай үйл ажиллагаагаа илүү уялдуулах хэрэгтэй. Германы хамтын ажиллагааны нийгэмлэг, Дэлхийн банк, Адам смит байгууллага болон ЕСБХБ-ны тусламжтайгаар зохицуулж баймаар байна. Олон улсын байгууллагаас өгсөн хөрөнгөд өөриймсөг хандаж ажилламаар байна.

Б.Баатарцогт: Ажлын албанаас гарч байгаа тайлан дээр нэгэнт Ашигт малтмал тухай хууль, Газрын тосны тухай хуульд орон нутагт орлогын тодорхой хувийг төвлөрүүлэхээр хуульчилсан байдаг, үүнийг хийхгүй байгаа нь хууль зөрчөөд байгаа асуудал юм. Үүнийг ил тод болгож тавих ёстой. Үүний цаана баялаг бүтээж байгаа байгууллагууд ажиллаад байдаг. Ажлаа хийх гээд орон нутагт очихоор хүлээж авдаггүй, орон нутагт өгөөж нь харагдахгүй байна. Иймээс хуулинд зохицуулалт нь байгаад хуулийн дагуу орон нутагт уул уурхай, газрын тосны үйл ажиллагаа явуулж байгаа компаниудаас оруулсан төлбөр нь орон нутагт хуваарилагдаж, өгөөж нь нэмэгдэх юм. Энэ талаар орон нутгийнхан, болон уул уурхай эрхэлж байгаа байгууллагуудаас санал тавьж байгаа. Энэ асуудлыг нээлттэй болгож, зөвлөмжиндөө тусгаж оруулах санал байна. Сангийн яамны Орон нутгийг дэмжих санд уг орлого төвлөрсөн байдаг. Манай байгууллагаас Газрын тосны бүтээгдхүүн хуваах гэрээг ил болгох, лицензийн мэдээллийг гаргах, солбилцлыг ил тод болгох зэрэг мэдээллүүдийг гаргах боломжтой. Манай кадастрын системд шинэчлэлт хийнэ. Төсөв мөнгө нь хүрдэг бол жаахан нэмэгдүүлвэл сайн байна, хүн хүч сургах, бэлтгэх ажлууд байна. 2018 оны төсөвт манай яаманд 24 тэрбум төгрөг батлагдсан, энэ нь бусад яамтай харьцуулахад маш бага мөнгө. Бид жилдээ 200 гаруй тэр бум төгрөгийг төсөвт төвлөрүүлсэн байдаг. Кадастрын системийн боловсронгуй болгоход төсөв мөнгө шаардлагатай. Тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн аль болох ил тод болгох, мэдээллийг хүртээмжтэй болгоход бид чиглэж ажиллаж байгаа. Мэдээлэл технологийн төвийг ажиллуулж байна, энэ баазад санаачилгаас шаардаж байгаа мэдээллийг нэг бүрэлдхүүн хэсэг болгон оруулах нь зүйтэй гэж харж байгаа. Ингэснээр мэдээллийг ил тод, хүртээмжтэй болоход чухал нөлөөтэй болно.

Б.Дэлгэрмаа: Манай гишүүдээс орон нутагт дэд зөвлөлийг сайн ажиллуулах санал гарсан. Жишиг сумдын байгуулах төсөл хэрэгжиж байна. Үүний Гурвантэс суманд ажиллаж байгаа зөвлөл сайн ажилладаг, тэндээс орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа компаниудын талаар мэдээлэл ирдэг. Зөвлөлөөс Гурвантэс суманд ажиллаж байгаа Баатарван гэдэг компани маш муу ажиллаж байна, үүнийг анхааралдаа авахыг албан ёсоор дамжуулж өгөхийг хүссэн.

## **5.ХЭЛЭЛЦСЭН НЬ: ОУИТБС-ын орон нутгийн туршилтын төслийн явцын танилцуулга**

Н.Энхжаргал: Сайн байцгаана уу, манай компани 2017 оны 3 дугаар сараас эхлэн жишиг 5 сумыг хэрэгжүүлэх төсөл дээр ажиллаж байна. Сонгогдсон сумд маань өөр өөрийн онцлогтой, өөр өөрийн асуудалтай байдаг. Иргэний нийгмийн Баярсайхан, Баярмаа, Цэрэнжав нар хамтран ажиллаж, хөдөө орон нутагт ажилласан. Ерөө сумын удирдлагууд олддоггүй 2 удаа очиход Засаг дарга нь байхгүй, хүмүүс нь цуглардаггүй газар байсан. Улсын хэмжээний 330 сумаас сонгогдчихоод ойлгохгүй, үйл ажиллагааг дэмжихгүй байна. Ийм сумыг яах вэ? гэсэн асуудал яригдаж байсан. Заамарын иргэдийг цуглуулж, нээлттэй өдөрлөг хийгээд, орой нь хүлээн авалт хийсэн. Иргэд ярихдаа, уул уурхайн компаниуд өмнө нь хэзээ ч ийм ажил хийж байгаагүй гэж байсан. Дэлгэрэх бол уул уурхайн үйл ажиллагаа явуулаагүй сум учраас анхнаас нь зөв мэдээллийг өгөхийг зорьсон. Бид эхлээд институциа бэхжүүлье гээд мэдээллийн танхим байгуулах, сургалт явуулах, дэд зөвлөлөөр дамжуулан нилээд ажлыг хийхээр төлөвлөөд ажиллаж байна. Энэ оны 3 дугаар сард гадаадын зөвлөх ирж, хэрэгцээний судалгаа хийсэн, бид хамтдаа 5 сумаараа явсан, судалгаан дээр үндэслэн хэрэгцээний тайлан гарсан. Стратегийг боловсруулсан, сум болгонд ажлын төлөвлөгөө гаргасан. Бид туршилтын сум учраас бичиг баримт дээрээ анхаарч ажиллаж байгаа. Энэ 5 сум амжилттай болвол дараагийн 10 сумдад хэрэгжихэд чухал ач нөлөөтэй. Бид мэдээллийн ажилтанг сум бүрт ажиллуулж байна, тэднийг цалинжуулж байгаа. Сум бүрт мэдээллийн төв байгуулсан. Заамарт иргэд нь сайн оролцсон, Гурвантэсийн засаг дарга сайн оролцсон компаниуд дунд зэрэг оролцсон. Бид мэргэжлийн холбоотой хамтран ажиллаж байна, Наранзаяа сайн тусалсан. Ерөө, Дэлгэрэх сум дээр дэд зөвлөл байгуулагдаагүй бусад сумдад дэд зөвлөл байгуулан ажиллаж байна. Сумдын мэдээллийн ажилтнуудыг тогтвортой ажиллуулах, санхүүжилтийг шийдвэрлэх зэрэг хэд хэдэн саналыг боловсруулсан, ажлыг шат дараатайгаар хийх ёстой. Би цаашдаа зардал багатайгаар нийгмийн сүлжээ ашиглан ажиллаж болох арга замыг судална. Харилцааны ажлыг хийхийн тулд хүмүүсээ чадавхжуулах шаардлагатай.

Б.Энх-Амгалан: Бидний санаачилга нь гурван талын оролцоог хангах зорилготой санаачилга юм. Орон нутагт төр иргэн хоёр нь нэг талдаа, олборлогч нь нөгөө талдаа гарчихаад байх шиг байна. Уул уурхай хөгжинө, гэхдээ зөв уул уурхай хөгжөөсэй. Манай байгууллагын эрхэм зорилго бол уул уурхайгаар дамжин Үндэсний хөгжилд нэмэр болох үйлдвэрлэлийг дэмжинэ гэсэн зорилготой байх ёстой. Хууль зөрчиж байгаа үйл ажиллагаатай тэмцэж таарна, үүнээс засаад залруулаад, улсад татвараа төлөөд явж байгаа байгууллагад тээр болохгүй байх нь зүйтэй. 2018 оны тухайд төрийн өмчийн сургалтуудыг больё. Энэ нь бидний санаа зовдог асуудал биш, компани болгон маркетингийн албатай байгаа. Танай төсөл ямар өртөгтэй хэрэгжиж байна.

Н.Энхжаргал: 36,000 еврогийн өртөгтэй.

Б.Энх-Амгалан: Мөнгө цааш нь болдог бол төсөл хэрэгжих нэгжүүдийг улам олон болгоод, үр дүн нь үйл ажиллагааг дэмжихэд хөрс суурь болох тийм ажлыг хийх, хөрөнгө олох талаар анхаарч ажиллах нь зүйтэй. Төр бол мөнгө өгч чадахгүй, гаднын санхүүжилт босгох талаар судлаарай. /Танилцуулгыг хавсаргав/  
Ирэх жилээс эхлэн төр засгаас баталгаажсан кадастрын бааз датаг баяжуулах ажлыг хийгээд, үүнийг суртчилах ажлыг хийе. Тайланг гарын авлага болгож явъя. Санаачилга нь сайн дурынх учраас манай компани нэгдэхгүй орохгүй гэвэл яаж ч болохгүй юм байна. Ил тодын санаачилга нь ухамсрын ёс суртхууны үндсэн дээр явуулж байгаа үйл ажиллагаа учраас жингийн тааруулахгүй бол болохгүй байх. Үүний тулд соён гэгээрүүлэх ажиллагаа хийх ажилд чиглэн

ажиллая. Миний хэлсэн саналуудыг төлөвлөгөөндөө тусгаад явах байх, хуралдаа ирсэн та бүхэнд баярлалаа, дараагийн хурлыг жич тогтоё. Баярлалаа.

Хуралдаан 13,45 цагт өндөрлөв.

Хурлын тэмдэглэлтэй танилцсан:

Ерөнхий сайдын ахлах зөвлөх,  
ОУИТБС-ын Үндэсний зөвлөлийн  
нарийн бичгийн дарга, ажлын хэсгийн  
ахлагч



Б.Энх-Амгалан

Ажлын хэсгийн нарийн бичгийн дарга



Ш.Цолмон

Хурлын тэмдэглэл хөтөлсөн:

Ажлын албаны санхүүгийн ажилтан



А.Отгонтунгалаг